

Тендерийн урилга

Огноо:	2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр
Зээл болон буцалтгүй тусламжийн дугаар болон нэр:	Зээл 3843-МОН: Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр - I үе шат Буцалтгүй тусламж 0672-МОН: Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр - I үе шат
Гэрээний дугаар болон нэр:	Б04: Яаралтай түргэн тусламжийн эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх
Тендер хүлээн авах хугацаа:	2026 оны 5 дугаар сарын 22-ны өдөр, 14:00 цагт (Улаанбаатарын цагаар)

1. Монгол улс нь Азийн хөгжлийн банк (АХБ)-аас **Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр - I үе шат** төслийг санхүүжүүлэх зорилгоор энэхүү санхүүжилтийг хүлээн авсан бөгөөд уг хөрөнгөөр дээр дурдсан гэрээний төлбөрийг санхүүжүүлэх зорилготой болно. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендерт оролцогчдод нээлттэй байна.
2. Эрүүл мэндийн яам (“Захиалагч”) нь эрх бүхий тендерт оролцогчийг **Яаралтай түргэн тусламжийн эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх** битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.
3. Нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (дотоодод зарлан мэдээлэх)-ыг АХБ-ны **нэг үе шаттай: нэг дугтуйт** горимын дагуу зохион байгуулах ба тендерийн баримт бичигт заасан эрх бүхий орны бүх тендерт оролцогчдод нээлттэй байна.
4. Энэхүү тендер шалгаруулалтад зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шаардлагыг хангасан эрх бүхий тендерт оролцогч оролцоно. Үүнд:
 - а) Хүлээгдэж буй шүүхийн маргаан болон арбитрын зарга:**
Хэрэв тендерт оролцогчийн цэвэр хөрөнгө болон/эсхүл төлбөрийн чадварт нөлөөлөх аливаа хүлээгдэж буй шүүхийн маргаан, арбитрын хэрэг эсвэл бусад материаллаг үйл явдал байвал тэдгээрийг тендерт оролцогчийн эсрэг шийдвэрлэгдсэн гэж үзнэ. Ийм тохиолдолд эдгээрийн нийт дүн нь тендерт оролцогчийн нийт хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцсон цэвэр хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.
 - б) Гэрээний туршлага:**
Тендерт оролцогч нь сүүлийн гурван (3) жилийн хугацаанд (2023, 2024, 2025) үндсэн ханган нийлүүлэгчээр ажиллаж, тус бүр нь 1,200,000 (нэг сая хоёр зуун

мянга) ам.долларын үнийн дүнтэй дор хаяж гурван (3) гэрээг амжилттай хэрэгжүүлсэн туршлагатай байна. Эдгээр гэрээнүүдийн шинж чанар болон төвөгшил нь эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гэрээтэй дүйцэхүйц байна.

с) Техникийн туршлага:

Тендерт оролцогч нь санал болгож буй бараа нь дараах шаардлагыг хангаж байгааг нотлох ёстой. Үүнд:

- дор хаяж гурван (3) жилийн турш үйлдвэрлэгдсэн байх;
- сүүлийн гурван (3) жилд (2023, 2024, 2025) ижил төрлийн болон ижил техникийн үзүүлэлттэй дор хаяж гурван (3) ширхэгийг борлуулсан байх;
- сүүлийн гурван (3) жилийн хугацаанд (2023, 2024, 2025) ашиглалтад оруулсан байх.

d) Өмнөх санхүүгийн гүйцэтгэл:

Тендерт оролцогчийн одоогийн санхүүгийн байдлын тогтвортой байдлыг нотлох зорилгоор сүүлийн гурван (3) жилийн (2023, 2024, 2025) аудитлагдсан санхүүгийн тайланг ирүүлнэ. Хэрэв оролцогчийн улсын хууль тогтоомжоор аудитлагдсан тайлан шаардахгүй бол захиалагчид хүлээн зөвшөөрөгдөх бусад санхүүгийн тайланг ирүүлж болно. Дор хаяж, хамгийн сүүлийн жилийн тендерт оролцогчийн цэвэр хөрөнгө (нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийг хассан дүн) эерэг байх ёстой.

e) Үйл ажиллагааны хэмжээ (Жилийн дундаж борлуулалт):

Сүүлийн гурван (3) жилд (2023, 2024, 2025) хэрэгжүүлж дуусгасан болон хэрэгжүүлж байгаа гэрээнүүдийн хүрээнд тендерт оролцогчийн хүлээн авсан нийт төлбөрийн дүнгээр тооцсон жилийн дундаж орлого нь дор хаяж 3,000,000 (гурван сая) ам. доллар байна.

f) Санхүүгийн нөөц хөрөнгийн шаардлага:

Мөнгөн урсгалын шаардлага болох 500,000 ам.долларыг хангахуйц хэмжээний бэлэн хөрөнгө, зээлийн шугам болон бусад санхүүгийн эх үүсвэрт эзэмших эсхүл хандах боломжтой байна.

g) Боловсон хүчний шаардлага:

Тендерт оролцогч нь Эрчимт эмчилгээ болон Яаралтай тусламжийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ашиглалт, техникийн үйлчилгээнд мэргэшсэн, зохих сургалтад хамрагдсан тав (5)-аас доошгүй эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженертэй байна. Инженер бүр нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн чиглэлээр, ялангуяа Эрчимт эмчилгээ болон Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн чиглэлээр тав (5)-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байна. Бүх инженерүүд нь Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерчлэл болон Электроникийн инженерчлэлийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байна. Инженерүүдийн боловсролын диплом болон сургалтын гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбарууд, мөн албан ёсны орчуулгын хамт тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ.

5. Дэлгэрэнгүй мэдээлэл авах болон тендерийн баримт бичигтэй танилцахыг хүссэн тендерт оролцогчид дараах хаягаар хандана:

Захиалагч : Эрүүл мэндийн яам
Харилцах ажилтан : А.Юмчмаа, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер
Хаяг : Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байрны өргөтгөл, Эрүүл мэндийн яам
Давхар/Өрөөний дугаар : 3 давхар, 304 тоот
Хот : Улаанбаатар хот
ZIP код : 11000
Улс : Монгол улс
Утасны дугаар : +976 11 329369
Цахим шуудангийн хаяг : procurement2@hsdp.org

6. Англи хэл дээр боловсруулсан тендерийн баримт бичгийг худалдан авахын тулд эрх бүхий оролцогчид дараах шаардлагыг хангасан байна:

- a. дээр дурдсан хаягт хандан **Б04: Яаралтай түргэн тусламжийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх** тендерт оролцох тухай албан хүсэлт гаргах ба;
b. үл буцаан олгох нөхцөлөөр **100 ам. доллар** эсвэл **360,000** төгрөгийн төлбөрийг доорх дансаар дамжуулан шилжүүлсэн байна:

<u>Гадаад шилжүүлэг</u>		<u>Дотоод шилжүүлэг</u>	
Payee's Name	: Improving Access to Health Services for Disadvantaged Groups Investment Program	Дансны нэр	: ЭБИЭМТҮХСХОХ МОН3843
Bank Name	: State Bank of Mongolia Ulaanbaatar, Mongolia	Банкны нэр	: Төрийн сан
Payee's Account No.	: 106000076051 (USD)	Дансны дугаар	: 100900011878 (MNT)
SWIFT Code	: STBMMNUB		
Corresponding Bank			
Bank Name	: Kookmin Bank		
SWIFT Code	: CZNBKRSE		
Account No.	: 7968USD019		

Тендерийн баримт бичгийг цахим шуудангаар илгээнэ. Алдагдал болон хугацаа хоцорсон хүргэлтэд ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

7. Тендерийг дараах хаягаар хүлээж авна:

Захиалагч : Эрүүл мэндийн яам
Харилцах ажилтан : А.Юмчмаа, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер

Азийн Хөгжлийн Банк

Хаяг : Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байрны өргөтгөл, Эрүүл мэндийн яам
Давхар/Өрөөний дугаар : 2 давхар, 203 тоот
Хот : Улаанбаатар хот
Улс : Монгол улс

- Тендерийг **2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14:00 цагаас (Улаанбаатарын цагаар)** өмнө хүлээн авна.
- Тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.
- Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусмагц тендерийг нэн даруй нээх ба тендерт оролцогчдын төлөөллийг өөрсдийнх нь хүсэлтээр байлцуулна.

8. Тендерүүдийг харьцуулахдаа Тендерийн баримт бичигт заасны дагуу дотоодын давуу эрхийг хэрэглэнэ.